ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 13 өдөр Дугаар А/37 Арвайхээр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, Төсвийн ерөнхийлөн захирагч Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээний хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сант сумын эрүүл мэндийн төвд эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ю.Ичинноров – Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Н.Амаржаргал – Тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Ц.Батжаргал-Нягтлан бодогч

М.Ганцэцэг- Статистик мэдээлэл хариуцсан ажилтан

Г.Гантөмөр - Оновчтой хөгжил ТББ-ын тэргүүн

2. Хууль тогтоомжийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж дүгнэлт, зөвлөмж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг үнэлгээний хороо (Ю.Ичинноров), тендерийн бичиг баримтыг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлэн архив, бичиг хэргийн ажилтад хүлээлгэж өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Н.Амаржаргал) нарт даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ОЮУНТУЯА

622501141

D:My.Doc./Tushaal/.EMG